МЭДЭЭ · 2025 оны 2-р сарын 20

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХАД ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛНЭ



Багануур дүүргийн прокурорын газраас хүүхдийн эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын үр дүнтэй хамтын ажиллагаа, оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн эсрэг аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн Цагдаагийн хэлтэс, Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын хэлтэс, Боловсролын хэлтэс, Ерөнхий боловсролын сургуулиудын алба хаагчидтай уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт дүүргийн прокурорын газраас "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгаалал", Хүүхдийн төлөө орон нутгийн салбар зөвлөлийн дарга бөгөөд дүүргийн засаг дарга С.Даваасүрэн "Дүүрэг дэх хүүхэд хамгааллын бодлого, чиглэл"-ийн талаар мэдээлэл хийж, тулгамдаж буй асуудлууд болон цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлсэн байна.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1089